



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР



2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 он

ӨМНӨХ ҮГ



Говьсүмбэр аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.

2016 онд тус аймгийн Аудитын газрын хамт олны хувьд дэвшүүлсэн зорилтоо 100 хувь ханган биелүүлсэн, хийж бүтээсэн ажлын үр дүн, үр өгөөж нэмэгдсэн, ажиллагсдын ажиллах орчин, нөхцөл, ажлын байр болон компьютер, техник хэрэгслэлийн хангалтыг сайжруулсан зэргээр нилээдгүй ахиц гарсан жил боллоо.

Аймгийн Аудитын газар 2016 онд **“Аудитын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэн, аудитын цахим технологийг бүрэн эзэмших”** гэсэн зорилтыг дэвшүүлэн, уг зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллахад гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа. Ингэснээр 2016 онд манай байгууллагын 1 төгрөгт ногдох тооцоолсон үр өгөөж **47.7** сая төгрөгт хүрлээ.

Цаашид аудитын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, дэвшүүлсэн зорилтоо бүрэн биелүүлж ажиллахад гол ажлаа чиглүүлэн ажиллах болно.

Бидний тайлантай танилцаж санал, зөвлөмжөө өгнө гэдэгт найдаж байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.ИЧИНХОРЛОО

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, 2017 ОНЫ ЗОРИЛТ

2016.12.21

Чойр хот

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Говьсүмбэр аймгийн Аудитын газар 2016 онд **“Аудитын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэн, аудитын цахим технологийг бүрэн эзэмших”** гэсэн зорилтыг дэвшүүлэн, уг зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллахад гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

2016 онд уг зорилтын хүрээнд нийт 10 бүлэг 60 үзүүлэлтээр жилийн үйл ажиллагаагаа төлөвлөн, Монгол Улсын Ерөнхий аудитортой үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллахад анхаарч ажилласнаар төлөвлөсөн 60 ажлыг 100 хувь гүйцэтгэж ажиллаа.

Мөн 2016 оны зорилтын хүрээнд аудитын цахим технологийг эзэмшиж, санхүүгийн тайлангийн аудитыг бүрэн СТАУС програм дээр гүйцэтгэж, гүйцэтгэлийн аудитын програмыг нэвтрүүлэн, цахим мэдээллийн санг бүрдүүлж ажилласан ба шат шатны чанарын хяналтыг цахим програмаар гүйцэтгэсэн зэрэг нь аудитын болон чанарын хяналтын ажлыг хөнгөвчилсөн, аудитын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний үр дүнтэй ажил боллоо.

ҮАГ-аас зохион байгуулагдсан зарим аудитуудын цахим сургалтуудад хамрагдан, шаардлагатай мэдээ, мэдээллийг хүлээн авч, аудитын явц, үр дүн болон тулгамдсан зарим асуудлуудын талаар тухай бүр санал солилцож, орон нутгийн шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгаа, тайланг зэргийг цахимаар ҮАГ-т хүргүүлж ажилласан зэрэг нь цаг хугацаа болон материаллаг зардлыг хэмнэх зэрэг үр дүнг бий болголоо.

Аймгийн Аудитын газар 2016 онд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 онд баталсан бүтэц орон тооны дагуу 7 орон тоотой, 176.8 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэртэйгээр үйл ажиллагаа явуулж, дэвшүүлсэн зорилтыг хангаж ажиллаа.



2016 онд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 80 байгууллагын санхүүгийн тайланд аудит, Гүйцэтгэл, Нийцлийн 26 аудитыг тус тус хийж дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 109/2257 хүн/өдөр зарцуулсан ба нийт 1733 илүү цаг ажиллалаа.

2015 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан 80 байгууллагын 56 байгууллагын санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 12 байгууллагад итгэмжлэл үзүүлж, 12 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Бие даасан дүгнэлт гаргасан 14 байгууллагын санхүүгийн тайланд ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын ирүүлсэн хуваарийн дагуу хараат бус Аудитын байгууллага буюу “Голден пейж аудит” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулан аудит хийлгэж ажиллалаа.


Гүйцэтгэл, Нийцлийн нийт 26 аудитын 13 аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар, 9 аудитыг өөрийн санаачлагаар, 4 аудитыг аймгийн ИТХ-ын хүсэлтээр тус тус хийж гүйцэтгэлээ.

2016 оны байдлаар аудитаар нийт 297,717.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн ба 4,744.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж, 492.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,837.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, 279,643.5 сая төгрөгийн 375 алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгч ажиллалаа.

2016 оны байдлаарх аудит, алдаа, зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийн нэгтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Аудитын төрөл	Аудитын тоо	Илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн /сая.төг/	Тогтоосон төлбөрийн акт /сая.төг/	Өгсөн албан шаардлага /сая.төг/	Бүртгэсэн үр өгөөж /сая.төг/	Үүнээс: Залруулсан	Өгсөн зөвлөмж /тоо/
Санхүүгийн тайлангийн аудит	80	8,850.2	59.4	632.4	691.5	4,738.0	145
Гүйцэтгэлийн аудит	12	281,914.9	364.2	7,073.4	5,399.0	6.6	151
Нийцлийн аудит	14	6,952.8	69.1	5,131.3	5,200.4	0,0	79
ДҮН	104	297,717.9	492.7	12,837.1	11,290.9	4,744.6	375

2016 онд аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн илрүүлэлт болон шийдвэрлэлтийн судалгааг диаграммаар харуулбал:



2016 онд дээрх төлбөрийн актны 47.8 хувь буюу 235.7 сая төгрөг, өгсөн албан шаардлагын 62.6 хувь буюу 8,032.0 сая төгрөгийг барагдуулан ажилласан ба төлбөрийн актын 41.2 хувь, албан шаардлагын 32.0 хувийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байгаа болно.

2016 оны аудитаар **11,018.4** сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж бүртгэснээс **8,440.3** сая төгрөгийн үр өгөөжийг тооцоолж ажиллалаа. Ингэснээр аймгийн Аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж **62.3** сая, тооцоолсон үр өгөөж **47.7** сая төгрөг тус тус боллоо.

Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудитын талаар:

2016 оны аудитаар орон нутгийн болон улсын төсвийн байгууллага, төсөл, сангийн нийт 80 санхүүгийн тайланд аудит хийж, тус аудитаар нийт 50/712 хүн/өдөр зарцуулж, нийт 1459 илүү цаг ажилласан байна. Илүү цаг ажилласан нь тус Аудитын газрын орон тооны хүрэлцээ муу байгаагаас шалтгаалж байгаа бөгөөд 1 аудитор дунджаар 365 илүү цаг ажилласан байна.

2016 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан 80 байгууллагын санхүүгийн тайлангийн 56 санхүүгийн тайланд нь бие даасан дүгнэлт гаргаж, 12 байгууллагад итгэмжлэл үзүүлж, 12 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан ба 14 байгууллагын санхүүгийн тайланд хараат бус аудитын байгууллага буюу “Голден пейж аудит” ХХК-иар гурвалсан гэрээгээр аудит хийлгэж ажиллалаа.



Санхүүгийн тайлангийн аудитаар бие даасан дүгнэлт гаргасан 56 байгууллагын 43 санхүүгийн тайланд “**Зөрчилгүй**”, 10 санхүүгийн тайланд “**Хязгаарлалттай**”, 3 санхүүгийн тайланд “**Сөрөг**” санал дүгнэлтийг тус тус өглөө.


Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,850.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 4,738.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 59.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, 632.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 145 зөвлөмж өгч ажиллалаа.

Тус аудитаар тогтоосон төлбөрийн актын 88.7 хувь буюу 52.7 сая төгрөгийг барагдуулахын зэрэгцээ өгсөн албан шаардлагын 85.3 хувь буюу 539.4 сая төгрөг, зөвлөмжийг 100.0 хувь буюу 145 зөвлөмжийн хэрэгжилтийг нь хангуулан ажиллалаа.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 691.5 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээс 248.5 сая төгрөгийн үр өгөөжийг тооцооллоо. Ингэснээр санхүүгийн тайлангийн аудитаар бий болсон Аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 1.4 сая төгрөг болж байна.

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчил, шийдвэрлэлтийн судалгааг диаграммаар харуулбал:



Санхүүгийн тайлангийн аудитыг 4 аудитор гүйцэтгэж, аудитын чанарын хяналтыг аудитын менежер, Тэргүүлэх аудитор хэрэгжүүлэн ажилласан ба дунджаар 1 аудитор 17 аудитыг хийж гүйцэтгэлээ. Мөн МУ-ын Ерөнхий аудиторын баталсан хуваарийн дагуу хараат бус хөндлөнгийн аудитын “Голден пейж аудит” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж, 14 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийлгэлээ.

Аймгийн Аудитын газрын Тэргүүлэх аудитор, менежер, аудиторууд санхүүгийн тайлангийн аудитын СТАУС програмыг бүрэн эзэмшиж, бүх аудитыг тус програмаар гүйцэтгэсэн нь аудитын чанар, үр өгөөжийг сайжруулахын зэрэгцээ цаг хугацаа болон материаллаг зардлыг тодорхой хэмжээгээр хэмнэсэн үр дүнтэй ажил болсныг дурдахад таатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:
Үүнд:

➤ НББ, тайлагналтай холбоотой	4,367.8 сая,
➤ Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	2,804.2 сая,
➤ Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай	1,226.2 сая,
➤ Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилттэй	147.6 сая,
➤ Бусад зөрчил болон худалдан авалттай	134.5 сая,
➤ Арвилан хэмнэлт, үр ашигтай	119.9 сая,
➤ Улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй	50.0 сая.

Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн болон улсын төсвийн бүх байгууллагын дарга, нягтлан бодогч нарыг бүрэн байлцуулан аудитын нээлт хийн, мөн аудитын тайлан, гэрчилгээг байгууллагын дарга, нягтлан бодогч нарыг ирүүлэн гардуулан өгч тус аудитын үр дүн, илрүүлсэн алдаа зөрчлийн шалтгаан, үр дагавар, тэдгээрийг арилгах, өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар танилцуулж, санал солилцсон хэлэлцүүлгийг зохион байгуулж хэвшсэн нь тухайн байгууллагын удирдлагын түвшинд алдаа зөрчлийг ойлгуулах, уг алдаа зөрчлүүдийг дахин давтан гарахгүй байх, байгууллагын удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах зэргээр олон талын ач холбогдолтой, үр дүнтэй ажил боллоо.

Аймгийн улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг байгууллага бүрээр болон балансын дансдаар нэгтгэн мэдээллийн санг бүрдүүлэхийн зэрэгцээ байгууллага бүр дээр хувийн хэрэг нээн ажиллуулж, тухайн байгууллагын эрсдэлийг болон илэрсэн алдаа зөрчлийг арилгасан эсвэл давтан гаргаж байгаа эсэхэд үнэлгээ өгч авах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байгаа нь аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэх чухал ажил боллоо.

Санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагуудын дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэхэд эрсдэлийн үнэлгээ хийхийн зэрэгцээ нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал нь НББОУС, СТОУС болон холбогдох хууль, журам, зааврын дагуу үнэн зөв бэлтгэгдэж, тайлагнагдсан, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг хэрхэн хангаж байгаа зэрэгт анхаарлаа чиглүүлэн АОУС, АДБОУС-ууд болон санхүүгийн аудитын журмыг мөрдөж ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 18.8 сая төгрөгийн ажил үйлчилгээний төлбөр авахаар гэрээ байгуулан ажилласан ба үүний 6.7 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод, 12.1 сая төгрөгийг хувийн аудитын компанийн аудитын төлбөрт олгохоор төлөвлөж, орон нутгийн төсөвт 6.7 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт авсан, мөн өмнөх оны аудитаар тавьсан акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй төрийн байгууллагын 13 албан тушаалтан болон холбогдох албан хаачдад арга хэмжээ тооцуулах тухай саналыг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

Өмнөх оны Санхүүгийн тайлангийн аудитаар тависан төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг 100.0 хувь хэрэгжүүлж ажиллалаа.

Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар:

2016 онд Гүйцэтгэлийн 10 аудит хийхээр төлөвлөж, тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын хүсэлтээр 2 аудитыг нэмж, нийт 12 аудитыг гүйцэтгэсэн ба төлөвлөсөн аудитыг бүрэн хийж аудитад нийт 35/1003 хүн/ өдөр зарцуулж ажиллалаа.

Дээрх 12 аудитын 4 аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар, 4 аудитыг өөрийн санаачлагаар, 4 аудитыг аймгийн ИТХ-ын хүсэлтээр тус тус хийж гүйцэтгэсэн ба уг аудитуудыг тодруулбал:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар:


- ✚ 2015 оны Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн,
- ✚ Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын үр дүн,
- ✚ Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл,
- ✚ АИТХ-д нэр дэвшсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын зарцуулалтад хийх аудит

Өөрийн санаачлагаар болон аймгийн ИТХ-ын хүсэлтээр:

- ✚ “Шивээ-Овоо” ХК-ийн санхүүгийн зарим үйл ажиллагааны үр дүн,
- ✚ ШШГА, 0425-р ангийн үйл ажиллагааны үр дүн,
- ✚ Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит
- ✚ Боловсрол, соёлын салбарын үйл ажиллагааны үр дүн
- ✚ Сүмбэр сумын 2-р цэцэрлэгийн санхүүгийн зарим үйл ажиллагаа
- ✚ Эрүүл мэндийн салбарын бүтэц, орон тоо, төсвийн зарим зардлын төлөвлөлт, зарцуулалтын үр дүн,
- ✚ Баянтал сумын "Талын-Илч" ОНӨААТҮГ-ын 2014-2015 оны санхүүгийн зарим үйл ажиллагааны үр дүн,
- ✚ Аймгийн Татварын хэлтсийн 2016 оны 3 улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагааны үр дүн болон орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Гүйцэтгэлийн аудитаар нийт 281,914.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн бөгөөд аудитын явцад 6.6 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 364.2 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,073.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдааг засах, дахин гаргахгүй байх 68 зөвлөмж өгч ажиллалаа.

Илрүүлсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт



Уг аудитаар нийт 7,437.6 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээс 5,397.9 сая төгрөгийн үр өгөөжийг тооцооллоо. Гүйцэтгэлийн аудитаар аймгийн Аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох тооцоолсон үр өгөөж 30.5 сая төгрөг боллоо.

2016 онд аудитаар тогтоосон төлбөрийн актны 37.6 хувь буюу 137.0 сая төгрөгийг, ба өгсөн албан шаардлагын 74.7 хувь буюу 5,260.9 сая төгрөг, зөвлөмжийн 45.0 хувийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба тогтоосон төлбөрийн актны 42.4 хувь, өгсөн албан шаардлагын 25.3 хувь, зөвлөмжийн 55.0 хувийн хэрэгжилтийг аудит хийгдсэн хугацаанаас шалтгаалан тооцох болоогүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн ангилалыг харуулбал: Үүнд:	
✚ Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой	433.0 сая,
✚ Улс, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой	234.9 сая,
✚ Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтөй холбоотой	11,832.4 сая,
✚ НББ, тайлагналтай холбоотой	11,623.2 сая,
✚ Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	336.1 сая,
✚ Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	3,340.8 сая,
✚ Худалдан авалттай холбоотой	253,710.3.4 сая.

Гүйцэтгэлийн аудитын явцад тухайн аудиттай холбоотой аймгийн Татвар, Санхүү, төрийн сан, Хөгжлийн бодлогын хэлтэс, Худалдан авах ажиллагааны газар, сумдын ЗДТГ, БОАЖГ, БСУГ, сургууль, цэцэрлэг, сумдын Санхүү, төрийн сангийн алба зэрэг холбогдох байгууллагуудын удирдлага, санхүүгийн болон ажил хариуцсан ажилтнуудыг байлцуулан аудитын явцад тус байгууллагуудын хоорондын харилцаа, ажлын уялдаа, холбооноос шалтгаалан гарч буй зарим алдаа зөрчил, түүний үр дагавар, уг алдааг засаж, залруулах талаар уулзалт, хэлэлцүүлэгийг зохион байгуулж, санал солилцож ажилласан нь тухайн ажил хариуцсан байгууллага, ажилтан нар өөр өөрсдийн хүлээсэн эрх, үүрэг болон хийж гүйцэтгэх ажил, тухайн байгууллагуудын ажлын уялдаа холбоог ойлгуулсан үр өгөөжтөй ажил боллоо.



Гүйцэтгэлийн аудитын явцад ҮАГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээллийг бүрэн гаргаж, мөн аудитын тайлан болон бусад холбогдох материалыг цахимаар болон цаасаар цаг хугацаанд нь хүргүүлж, ҮАГ-аас зохион байгуулсан цахим хурал, сургалтанд бүрэн хамрагдаж, гүйцэтгэлийн аудитын програмд орон нутагт улсын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудын мэдээллийг оруулж, цахим мэдээллийн санг бүрдүүллээ.

Гүйцэтгэлийн аудитуудаар илрүүлсэн алдаа, зөрчлийг холбогдох байгууллагын эрсдэлийн мэдээллийн санд бүртгэж, эрсдэлийг нь үнэлэн, эрсдэлийн түвшинг тогтоож ажиллалаа.

Өмнөх онд хийгдсэн Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон төлбөрийн актны үлдэгдэл 388.4 сая төгрөгийн 97.3 хувь буюу 378.0 сая, албан шаардлагын үлдэгдэл 511.4 сая төгрөгийн 94.0 хувь буюу 480.7 сая төгрөгийг тус тус барагдуулж ажиллалаа.

Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар:

2016 онд Нийцлийн 9 аудит хийхээр төлөвлөж, тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын хүсэлтээр 5 аудитыг нэмж гүйцэтгэн нийт 14 аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд тус аудитад нийт 24/542 хүн/ өдөр зарцуулж ажилласан ба 154 илүү цаг ажиллалаа.

Дээрх 14 аудитын 11 аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар, 2 аудитыг өөрийн санаачлагаар, 1 аудитыг аймгийн ИТХ-ын хүсэлтээр хийж гүйцэтгэлээ. 2016 онд хийж, гүйцэтгэсэн аудитуудыг тодруулбал:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар:

- ✚ 2015 оны Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт,
- ✚ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт,
- ✚ 2016 оны аймгийн ИТХ-ын сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоох.
- ✚ 2016 оны сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоох
- ✚ Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн
- ✚ Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилт
- ✚ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
- ✚ УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэл
- ✚ Сум дүүргийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл
- ✚ Аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт аудит хийх
- ✚ Сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт аудит хийх

Өөрийн санаачлагаар болон аймгийн ИТХ-ын хүсэлтээр:

- ✚ Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт,
- ✚ ГХБХБГ-ын Газрын тухай хуулийн хэрэгжилт, хяналтын зардлын зарцуулалт.
- ✚ Сумдын Сум хөгжүүлэх сангийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн аудит

Нийцлийн аудитаар нийт 6,952.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн бөгөөд 69.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,131.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдааг засах, дахин гаргахгүй байх 79 зөвлөмж өгч ажиллалаа.



Уг аудитаар нийт 5,200.4 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээс 2,357.3 сая төгрөгийн үр өгөөжийг тооцооллоо. Тус аудитаар аймгийн Аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох тооцоолсон үр өгөөж 13.3 сая төгрөг байна.

2016 онд тус аудитаар тогтоосон төлбөрийн актны 66.6 хувь буюу 46.0 сая төгрөгийг барагдуулсан ба өгсөн албан шаардлагын 45.0 хувь буюу 2,311.3 сая төгрөгийн хэрэгжилтийг хангуулан ажилласан ба тогтоосон төлбөрийн актны 28.0 хувь,

өгсөн албан шаардлагын 50.0 хувь, зөвлөмжийн 31.7 хувийн хэрэгжилтийг аудит хийгдсэн хугацаанаас шалтгаалан тооцох болоогүй байна.

Нийцлийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн ангилалыг харуулбал: Үүнд:

✚ Улс, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой	161.8 сая,
✚ Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтөй холбоотой	1,288.6 сая,
✚ Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	4,970.2 сая,
✚ Худалдан авалттай холбоотой	170.8 сая,
✚ НББ, тайлагналтай холбоотой	238.7 сая
✚ Дотоод хяналт хариуцлагатай холбоотой	26.5 сая
✚ Бусад	591.0 сая.

Нийцлийн аудитын явцад тухайн аудиттай холбоотой аймгийн Татвар, Санхүү, Төрийн сан, Хөгжлийн бодлогын хэлтэс, Худалдан авах ажиллагааны газар, ГХБХБГ зэрэг байгууллагууд болон Сумдын удирдлага, санхүүгийн болон ажил хариуцсан ажилтнуудыг байлцуулан аудитын явцад тус байгууллагуудын хоорондын харилцаа, ажлын уялдаанаас шалтгаалан гарч буй зөрчил дутагдал, тэдгээрийн шалтгаан, үр дагавар, уг алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх тухай уулзалт, хэлэлцүүлэгийг зохион байгуулж, санал солилцож ажилласан нь үр дүнтэй ажил боллоо.

Нийцлийн аудитын явцад НАГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээллийг бүрэн гаргаж, мөн аудитын тайлан болон бусад холбогдох материалыг цахимаар болон цаасаар цаг хугацаанд нь хүргүүлж ажиллахын зэрэгцээ НАГ-аас зохион байгуулсан цахим хурал, сургалтанд бүрэн хамрагдаж ажиллалаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн 2 аудитын үр дүнд тус аймагт шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэж мэдээллээ байршуулаагүй, мөн мэдээллээ дутуу, буруу байршуулсан зэрэг зөрчил дутагдалыг арилгуулах холбогдох зөвлөмжүүдийг өгч, уг алдаа зөрчлийг засуулж ажиллалаа.

Өмнөх онд хийгдсэн Нийцлийн аудитаар тогтоосон төлбөрийн актны үлдэгдэ 151.7 сая төгрөгийн 98.9 хувь буюу 150.0 сая төгрөгийг барагдуулж ажиллаа.

Тавдугаар бүлэг. Аймгийн ИТХ-ын хүсэлт, өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар:

2016 онд аймгийн ИТХ-ын хүсэлтээр аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагаа, ХЭДС-ийн зарцуулалтад нийцлийн аудит, аймгийн ТЕЗ-ийн 2016 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудит, өөрийн санаачлагаар аймгийн ШШГА, 0425-р ангийн үйл ажиллагааны үр дүн, Шивээ-овоо ХК-ны үйл ажиллагааны үр дүнд 16 гүйцэтгэлийн аудит, ГХБХБГ-ын Газрын тухай хуулийн хэрэгжилт, хяналтын зардлын зарцуулалтад, Сумдын СХС-ийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд 8 нийцлийн аудит, нийт 24 аудитыг тус тус хийж гүйцэтгэлээ. Уг аудитуудад нийт 35/974 хүн/өдөр зарцуулж, 168 илүү цаг ажиллалаа.

Тус аудитуудаар нийт 7,655.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 426.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,229.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд

албан шаардлага өгч, алдаа, зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх тухай 78 зөвлөмж өглөө.

Тус аудитаар илрүүлсэн зөрчлийн 71.5 хувь нь холбогдох хууль эрх зүйн актыг зөрчсөн, 18.8 хувь нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 2.4 хувь нь улс, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй, 3.4 хувь нь дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 3.8 хувь нь бусад зөрчил дутагдлууд байна.



Аймгийн ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар гүйцэтгэсэн аудитуудаар нийт 7,655.8 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээс 5,431.3 сая төгрөгийн үр өгөөжийг тооцооллоо. Тус аудитаар аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох тооцоолсон үр өгөөж 30.7 сая төгрөг байна

Зургаадугаар бүлэг. Аймгийн ИТХ-д үзүүлэх үйлчилгээний талаар:

Аймгийн 2017 оны төсвийн төсөлд 6 төрлийн 375.4 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх, 4 төрлийн 270.5 сая төгрөгийн зардал бууруулах саналыг оруулж, орлогыг 375.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн ИТХ-аар батлууллаа.

2016 онд 11 иргэнээс мэдээлэл, хүсэлт, өргөдөл ирүүлсний 3 өргөдөл нь аудит хийлгэх тухай, 9 нь аудитын бус бусад чиглэлээр ирүүлсэн өргөдөл, хүсэлт байлаа. Уг хүсэлт, өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох иргэдэд хариуг нь хүргүүлж ажиллалаа.

Долоодугаар бүлэг. Дотоод ажлын талаар:

2016 оны үйл ажиллагааны болон дотоод сургалтын, мөн Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллахын зэрэгцээ ЯАГ-ын шинэчлэн баталсан Дотоод журмын дагуу байгууллагын дотоод журмыг шинэчлэн, мөн байгууллагын ажилласдын үр дүнгийн гэрээ дүгнэх, үнэлэх журмыг боловсруулж тус тус баталлаа.

Байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайланг хэвлүүлж, ЯАГ болон аймгийн Номын санд хүргүүлсэн, мөн “Байгууллагын 1995-2016 оны түүхэн товчоо-дурсамж” номыг эмхтгэн бэлтгэж, хэвлүүллээ.

2015 онд МУ-ын Ерөнхий аудитортой байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнүүлж, Байгууллагын дарга, Тэргүүлэх аудитор Монгол Улсын Ерөнхий аудитортой, аудиторууд болон үйлчилгээний ажилтан Тэргүүлэх аудитортой 2016 оны үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, аудиторуудын 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан ЯАГ-т хүргүүллээ.

2016 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу ҮАГ-ын САГ-аас зохион байгуулсан СТАУС-ын сургалтанд хамт олноороо, мөн ГАГ, НАГ-уудаас зохион



байгуулсан 5 удаагийн цахим сургалтанд бүрэн бүрэлдэхүүнээр оролцсон.

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан журмын дагуу мэргэшлийн түвшин тогтоох шалгалтад аудитын менежер Б.Сарантуяа, аудитор Г.Наранбаяр нар хамрагдаж, шалгалтаа амжилттай өглөө.

Аймгийн ЗДТГ болон ММНБИ-ын орон нутгийн салбараас зохион байгуулсан 4 удаагийн сургалтанд аудиторууд бүрэн оролцож, аудитор Л.Отгонпүрэв, Г.Наранбаяр нар мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхээ авлаа.

Байгууллагын дотоод сургалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу аудиторуудад 2016 онд шинэчлэн батлагдсан “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж, тайлагнах журам”-ын дагуу статистик мэдээг боловсруулан гаргах тухай, “Цагийг хэрхэн зөв удирдах вэ, ажлын цаг ашиглалтын талаар”, “Архив, бичиг хэргийн хөтлөлтийг хэрхэн боловсруулах, баримт материалыг архивлах тухай”, ҮАГ-ын мэргэшлийн түвшин тогтоох шалгалтад бэлтгэж, цахим тестийн сангаас тестийг ажиллаж, 4 удаагийн 8 цагийн сургалтыг зохион байгууллаа.



Байгууллагын дотоод журмын дагуу аудиторчуудын жилийн үр дүнгийн гэрээний биелэлт, ажлын үр дүнг дүгнэж, эхний хагас жил болон жилийн эцсээр хамт олноо хошуучлан ажилласан менежер Б.Сарантуяа, ахлах аудитор Д.Оюунбат, аудитор Л.Отгонпүрэв нарыг шагнаж урамшууллаа.

Байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор аудитын менежер Б.Сарантуяа, ахлах аудитор, ахмад ажилтан Д.Оюунбатыг орон сууцны дэмжлэгт хамруулах хүсэлтийг ҮАГ-т уламжлан хүргүүлээ.

Мөн Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо ҮАГ-ын тодорхойлолтоор “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр, ахлах аудитор Ц.Батсайхан Монгол Улсад Санхүү, бүртгэлийн алба үүсч хөгжсөний 105 жилийн ойг тохиолдуулан ҮАГ-ын “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдаж, аудитор Л.Отгонпүрэв, Г.Наранбаяр нарыг “Санхүү банкны Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнуулахаар тодорхойлолтыг Сангийн яаманд хүргүүлэв.

Аудиторуудын гүйцэтгэж буй аудит тус бүр дээр Ашиг сонирхолгүйн тухай мэдэгдэл гаргуулан авахаас гадна 2016 онд ашиг сонирхолын зөрчил, авилгаас ангид байж, “Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрмийг чанадлан сахиж, мөрдөж ажиллах” тухай мэдэгдлийг оны эхэнд бүх аудиторуудаас гаргуулан авч хувийн хэрэгт нь хавсаргахын зэрэгцээ ажилтнуудын хувийн хэргийг баяжилтийг хийлээ.

Байгууллагын мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах зорилгоор аймгийн телевизээр 2 удаа, Чойрын толь сонинд 1 удаа ярилцлага өгөхийн зэрэгцээ байгууллагын ил тод байдлын самбарыг гаргаж, ажиллууллаа.

2016 онд Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын А тушаал 33, Б тушаал 6 гарч, тайлант онд ирсэн 426 бичигний 39.4 хувь нь хугацаатай бичиг бөгөөд хугацаатай бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагуудад нь тухай бүр хүргүүлж, ҮАГ болон бусад байгууллагуудад 291 бичиг, албан тоотыг гаргаж, ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаанд шилдэг туршлага нэвтрүүлэх, бусад байгууллагын туршлага судлах, ажилтнуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрөөх зорилгоор Төв аймгийн Аудитын газрын үйл ажиллагаа, аудитын туршлагаас судлахын зэрэгцээ 2 байгууллагын дунд волейболын нөхөрсөг тэмцээн, Аглаг бүтээлийн хийдийг үзэх хамтарсан аялалыг зохион байгууллаа. Байгууллагын ажилтнуудыг аймгийн нэгдсэн эмнэлэгийн үзлэгт үнэ төлбөргүйгээр хамрууллаа.



Байгууллагын 3 ахмад ажилтанг 2016 оны цагаан сар, ахмадын баяраар 2 удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ эх үрсийн баяраар байгууллагын ажилтнуудын хүүхдүүдэд баярын бэлэг бэлтгэн өгч урамшууллаа.

2016 онд хийгдсэн аудитын болон бусад баримт материалыг архивлаж, байгууллагын архив хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч, байгууллагын статистик мэдээг шинэчлэгдсэн журмын дагуу гаргаж ЯАГ-ын СБТГ-т хүргүүлээ.

Долоодугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар:

Аудитын газар 2016 онд нийт 176.8 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны төсөв батлагдаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулж, өглөг, авлагагүй ажиллалаа.

2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 2016 оны эхний 8 сарын байдлаар төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр, мөн 2017 оны төсвийн төсөл, байгууллагын хөрөнгийн судалгаа болон бусад санхүү, төсөвтөй холбоотой мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж ЯАГ-т хүргүүлж ажиллалаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, ажил гүйлгээг ЯАГ-ын шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбар, ил тод байдлын самбаруудад тогтмол байршуулж ажиллалаа.

Наймдугаар бүлэг. Дүгнэлт, ЯАГ-т уламжлах саналын талаар:

Дүгнэлт: 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээг 100 хувь хэрэгжүүлэн ажиллахаас гадна шинэлэг байдлаар доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн нь аудитын чанар, үр өгөөжийг дээжлүүлэхэд чухал ач холдогдолтой ажил боллоо. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудит болон Гүйцэтгэл, Нийцлийн аудитаар улс, орон нутгийн төсвийн болон улс, ОНӨҮГ, байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарыг бүрэн байлцуулан аудитын нээлтийг хийж, мөн аудитын тайлан, гэрчилгээг байгууллагын дарга, нягтлан бодогч нарт албан ёсоор гардуулан өгч тус аудитын үр дүн, илрүүлсэн алдаа зөрчлийн шалтгаан, үр дагавар, тэдгээрийг арилгах, өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар танилцуулж, санал солилцсон уулзалт, хэлэлцүүлэгийг 2 дахь жилдээ зохион байгуулж, хэвшил болгож байгаа нь тухайн байгууллагын удирдлагын түвшинд алдаа зөрчлийг ойлгуулах, уг алдаа зөрчлүүдийг дахин давтан гарахгүй байх, байгууллагын удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах зэргээр олон талын ач холбогдолтой, үр дүнтэй ажил болж, үр дүнгээ агч байна,
- Тус аймгийн Улс болон орон нутгийн төсөвт байгууллагуудын жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг байгууллага бүрээр, мөн балансын дансдаар нэгтгэн мэдээллийн санг бүрдүүлэхийн зэрэгцээ байгууллага бүр дээр хувийн хэрэг нээн ажиллуулсан тухайн байгууллагын эрсдэлийг үнэлж, эрсдэлийн түвшин тогтоосны дагуу тухайн байгууллагад тусгайлан хэрэгжүүлэх горим сорилыг тодорхойлон, төлөвлөж ажиллаж байгаа нь аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэх, аудитуудын ажлыг хөнгөвчлөх чухал ажил болж байна,
- 2016 оны аудитын төлөвлөгөө, хөтөлбөр болон аудитын тайлангуудыг ил тод, нээлттэй байлгах үүднээс байгууллагын мэдээллийн самбараас гадна байгууллагын ил тод байдлын самбар гаргаж, мэдээллээ бүрэн байршуулж ажиллалаа.
- 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг СТАУС програмаар гүйцэтгэсэн ба ҮАГ-аас зохион байгуулсан Мэдээллийн технологийг сайжруулах, СТАУС програм ажиллах, тус програмын ашиглах, сайжруулах хүрээнд зохион байгуулсан сургалтанд бүрэн бүрэлдэхүүнээр оролцож, холбогдох мэдээллийг авахын зэрэгцээ тус програм дээр ажиллахад хүндрэлтэй болон дутуу хийгдсэн зайлшгүй хийх асуудлын талаар саналаа хүргүүлж, танилцуулж ажиллалаа.

- УАГ-ын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дотоод аудитын алба болон Чанарын баталгаажуулалтын албанаас аймгийн Аудитын газрын үйл ажиллагаа, гүйцэтгэсэн аудитуудын чанар стандартын хэрэгжилтийг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөхийн зэрэгцээ арга зүйн зөвлөмж өглөө. Уг шалгалтаар хангалттай үнэлгээ авсан ба шалгалтын мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.



- Аймгийн ИТХ болон орон нутгийн удирдлагын дэмжлэгээр Аудитын газрын ажиллагсдын ажиллах нөхцлийг сайжруулан 1 өрөө нэмж авсан ба шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад орон нутгаас 25.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг батлуулан авч, зарим шаардлагатай компьютер, техник хэрэгслүүдийг худалдан авч ажиллагсдын ажиллах нөхцлийг сайжрууллаа.

Санал: УАГ-ын удирдлагад доорх санал, болон хүсэлтүүдийг гаргаж байна.Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх СТАУС програмын дутуу, хийгдэх шаардлагатай ажлуудыг 2017 оны Санхүүгийн тайлангийн аудитаас өмнө дуусгах, ажилбаруудын уялдаа холбоог сайжруулах, бүх ажлыг програмын ажлын талбар дээр хийж гүйцэтгэдэг болгох,
- Гүйцэтгэлийн аудитын програмын сургалтыг орон нутагт зохион байгуулах, програмыг зөвхөн цахим мэдээллийн сан хэлбэрээр ашиглахгүйгээр гүйцэтгэл, нийцлийн аудитыг иж бүрнээр хийж гүйцэтгэх, орон нутгийн хөрөнгө оруулалт болон бусад аудитыг хийж болохуйцаар сайжруулах,
- Тус аймгийн Аудитын газрын орон тоо хүрэлцээгүй байгаагаас аудиторчуудын ажлын ачаалал маш өндөр, мөн төрөлжсөн аудитын баг ажиллуулах боломжгүй байна. Тус байгууллагын бүх аудитыг 4 аудитор гүйцэтгэж байгаа бөгөөд

санхүүгийн тайлангийн аудитын хугацаатай давхцаж гүйцэтгэл, нийцлийн аудитууд хийгдэж байгаа нь аудитын чанар үр өгөөжид сөрөгөөр нөлөөлөхөөс гадна аудиторуудын эрүүл ахуйн нөхцөл, эрүүл мэндэд нөлөөлж байна. Тухайлбал:2016 оны эцэст аудитор Л.Отгонпүрэв эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөөд байна. Иймд манай байгууллагын орон тоог 2 аудиторроор нэмэгдүүлж, төрөлжсөн аудитын баг ажиллуулах боломж бүрдүүлж өгөх,

- Байгууллагын албан ажлын хэрэгцээнд ашиглагдаж байгаа машины ашиглалтын хугацаа дуусаж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул шинээр солиулах,
- Байгууллагын аудиторуудын тав тухтай байдлыг хангах зорилгоор өрөө, тасалгаанд засвар үйлчилгээ хийх санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх,
- Аудитын мэргэшлийн шалгалтыг амжилттай өгсөн 4 аудиторын цалингийн болон зэрэг дэвийн нэмэгдлийн асуудлыг шийдвэрлэж өгөх,
- Боловсон хүчний мэдлэг, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, ажлын туршлага эзэмшүүлэх шаардлагын дагуу аймгийн Аудитын газрын аудитор, шинжээчдийг ҮАГ-аас зохион байгуулан гадаад улс орнуудад хийж буй сургалтууд болон ЭСЯ-ын шалгалтанд хамруулж өгөх. /аудиторууд сүүлийн 6-7 жил гадны улс оронд зохион байгуулсан ямар нэгэн сургалтанд хамрагдаагүй болно/

ТАЙЛАНГ ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.ИЧИНХОРЛОО.